Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2024.02.26

## Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2024 он 02 сарын 26

**ТОВЧ**

- Японы хөрөнгийн зах зээлийн NIKKEI 225 индекс 1989 оны оройн цэгээ давсан байна.
- NVIDIA 4-р улирлын тайлангаа танилцуулснаар хувьцааны ханш өнгөрсөн долоо хоногт 24.2%-ийн range өсөлтийг үзүүллээ.
- RIVIAN компанийн тайлан зарлагдсанаар хувьцааных нь ханш 26%-иар уналаа.
- MMC компани 89 сая ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээг үзэглэлээ.
- БНХАУ-ын банкнууд мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлэн барьсаар байна

| | |
|---|---|
| Dow Jones | 39,131.53 |
| S&P 500 | 5,088.80 |
| Nasdaq | 15,996.82 |
| DAX | 17,419.33 |
| FTSE 100 | 7,706.28 |
| S&P/ASX 200 | 7,643.60 |
| HANG SENG | 16,725.86 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 0.16% | 1.30% | 2.68% | 3.83% | 18.98% | 26.51% |
| S&P 500 | 0.03% | 1.66% | 4.04% | 6.69% | 27.79% | 33.52% |
| Nasdaq | -0.28% | 1.40% | 3.50% | 6.56% | 39.50% | 21.26% |

2024 оны 02 сарын 26-ны 16:00



### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | -0.05% | 1.84% | 2.63% | 3.92% | 13.17% | 26.27% |
| FTSE 100 | -0.11% | -0.39% | 0.83% | -0.45% | -2.98% | 18.74% |

2024 оны 02 сарын 26-ны 16:00



### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.12% | -0.16% | 1.29% | 0.82% | 5.92% | 14.68% |
| Hang Seng | -0.63% | 2.88% | 4.19% | -2.50% | -16.66% | -42.65% |

2024 оны 02 сарын 26-ны 16:00



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ-ын жижиг зах зээлийн үнэлгээ бүхий хувьцаануудын өсөлт хоцрогдолтой байна:** АНУ-ын S&P500 индекс ерөнхийлөгчийн өдрөөс хойш өсөлтийг үзүүлсэн ч Russell 2000 индекс өнгөрсөн долоо хоногт 0.23% уналтыг үзүүлжээ. Түүнчлэн S&P500, NASDAQ индексүүд оройн цэгээ шалгасан ба NVIDIA компанийн зах зээлийн үнэлгээ $277 тэрбумд хүрлээ. Өнгөрсөн долоо хоногийн 3-дахь өдөр NVIDIA тайлангаа зарлаж орлого нь 265% өсөлттэй гарсан нь микро-чип болон хиймэл оюун ухааны салбар өсөлттэй байгааг илэрхийлсэн байна.

**ХНС-ийн захирагч Christopher Waller-ийн хэлснээр хүүгээ яаран буулгах шаардлагагүй:** Christopher Waller-ийн үзэж буйгаар АНУ-ын 1-р сарын инфляцын түвшин хүлээгдэж байснаас өндөр гарсан, ажил эрхлэлтийн түвшин саарсан зэргээс шалтгаалж 2023 оны сүүлийн хагаст үргэлжилсэн буурч буй инфляц хэвэндээ үргэлжилнэ гэжээ. Түүний үзэж буйгаар инфляц яваандаа 2.0%-д дөхөх тул хүүгээ яаран бууруулахгүйгээр зах зээлийн зарчимд даатгах хэрэгтэй гэсэн утгыг илэрхийлжээ.

**График 1: NVIDIA компанийн хувьцааны ханш /сараар/**




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

**Сар шинийн дараах бяцхан сэргэлт:** Луу жилийн цагаан сарын худалдан авалт нэмэгдсэн гэх хүлээлттэй холбоотойгоор БНХАУ-ын индексүүд нээгдсэн долоо хоногтоо өсөлттэй байлаа. Shanghai Composite Index 4.85%, CSI300 3.71%, Hang Seng Index 2.36%-ийн өсөлтийг тус тус үзүүлжээ.

**Аялал жуулчлалын орлого өсөлттэй гарлаа:** БНХАУ-ын Соёл, Аялал жуулчлалын Яамны мэдээлж буйгаар аялал жуулчлалын орлого өнгөрсөн баяруудын өдрүүдэд өнгөрсөн жилтэй харьцуулбал 47 хувиар өссөн нь цар тахлын өмнөх үеийг ч давсан үзүүлэлт байлаа.

**БНХАУ-ын банкнууд мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлэн барьсаар байна:** Мөнгөний бодлого хэрэгжүүлэх тал дээр БНХАУ-ын Ардын Банк банк санхүүгийн салбар луу 500 тэрбум юанийн урсгал хөрөнгө оруулалтыг дунд хугацааны өрийн хэрэгслүүдийн тусламжтайгаар оруулсан байна. Түүнчлэн, БНХАУ-ын Ардын Банк 5 жилийн прайм зээлийн хүүг 25 суурь нэгжээр бууруулж 3.95 хувь болгосон 2019 хойших хамгийн том хэмжээний бууралт билээ. Тус зээлийн хүү нь ипотекийн зээлийн хүүг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг бөгөөд үгээр асуудалтай тулгараад буй үл хөдлөх болон орон сууцны зах зээлийг сэргээхэд гэсэн оролдлого юм.

**График 2: JD.COM хувьцааны ханш**




JD.COM нь Британийн Currys дэлгүүрийг өөртөө нэтгэхээр төлөвлөөд буй ба тухайн компанийн жилийн орлого 12.0 тэрбум ам.доллар байна. Энэ нь JD.COM компанийн 2022 оны орлогын 7.9%-тай тэнцэж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# ТАЙЛАНГИЙН УЛИРАЛ ЭХЭЛЛЭЭ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.